



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/154/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Балжинням Утас:994353 Цахим хаяг:baljinnyamd@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х. ЕРГЕНБЕК ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлээгүй, зардлын санхүүжилтийн тооцоог тулган баталгаажуулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллаагүй, бараа материалын дансанд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийгээгүй, бараа материалын өртгийн бүртгэлийг үнэн зөв илэрхийлээгүй зэрэг алдаа зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.22-д "Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйл Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, 45.3 -д "энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудтай нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд сумын Ерөнхий боловсролын сургууль нь 31,194.5 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдаж, сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс 5,528.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэн авч, тайлант оны эцэст 28,814.3 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Ховд сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 8 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 89.4 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>101,905,838.81</u>	<u>223,866,468.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	480,400.00	110,837,633.87
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	480,400.00	110,837,633.87
3121	Төгрөг	480,400.00	110,837,633.87
31211	Төрийн сангийн харилцах	480,400.00	110,837,633.87
33	АВЛАГА	18,672,513.81	8,230,709.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,054.31	6,930,709.53
335	Бусад авлага	18,372,459.50	1,300,000.00
3351	Байгууллагаас авах авлага	18,372,459.50	1,300,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,690,000.00	1,690,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,690,000.00	1,690,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,690,000.00	1,690,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	81,062,925.00	103,108,125.00
351	Түүхий эд материал	-	147,200.00
35130	Эм боох материал	-	147,200.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	166,700.00	216,700.00
354	Хангамжийн материал	80,896,225.00	102,744,225.00
35420	Аж ахуйн материал	-	1,750,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,600.00	9,600.00
35450	Барилгын засварын материал	2,118,591.00	2,118,591.00
35460	Хүнсний материал	8,716,100.00	28,814,100.00
35470	Бусад хангамжийн материал	70,051,934.00	70,051,934.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,637,019,351.18</u>	<u>3,613,409,246.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,637,019,351.18	3,613,409,246.28
391	Газар	-	9,240,000.00
392	Биет хөрөнгө	3,591,721,924.20	3,558,871,819.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,500,373,650.00	3,500,373,650.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(130,148,580.28)	(164,066,922.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,121,234.00	246,289,734.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(137,636,262.15)	(145,532,845.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	205,399,108.86	205,399,108.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(98,176,735.43)	(125,935,349.75)
39217	Ном	40,789,509.20	42,344,443.92
393	Биет бус хөрөнгө	45,297,426.98	45,297,426.98
39301	Програм хангамж	1,075,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(765,573.02)	(765,573.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,988,000.00	44,988,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,738,925,189.99</u>	<u>3,837,275,714.68</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,734,595,867.23</u>	<u>3,837,275,714.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,734,595,867.23	3,837,275,714.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	837,165,419.00	837,165,419.00
51101	Өмч: - төрийн	837,165,419.00	837,165,419.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,032,438,384.51	2,135,118,231.96
51210	Өмнөх үеийн үр дүн	2,032,438,384.51	2,032,438,384.51

51220	Тайлант үеийн үр дүн	-	102,679,847.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,992,063.72	864,992,063.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,738,850,189.99</u>	<u>3,837,275,714.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,625,254,986.92	2,019,035,121.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,747,486.92	14,794,934.72
120	Нийтлэг татварын бус орлого	78,747,486.92	14,794,934.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,245,064.70	14,794,934.72
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	75,245,064.70	14,794,934.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,546,507,500.00	2,004,240,186.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,546,507,500.00	2,004,240,186.53
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,177,000.00	308,626,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,287,330,500.00	1,695,613,886.53
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,557,364,635.14	1,916,355,273.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,557,364,635.14	1,916,355,273.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,538,722,470.14	1,916,355,273.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	960,677,219.76	1,156,042,143.70
210101	Үндсэн цалин	721,028,091.33	1,109,750,095.50
210102	Нэмэгдэл	217,050,209.52	17,468,781.04
210104	Урамшуулал	22,598,918.91	28,823,267.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,614,106.39	150,839,130.98
210201	Тэтгэврийн даатгал	77,134,452.99	104,728,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,630,638.35	12,320,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,189,090.68	9,951,957.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,526,347.67	4,081,350.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,133,576.70	19,756,323.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,824,040.50	301,861,959.50
210301	Гэрэл, цахилгаан	11,851,240.50	9,785,524.34
210302	Түлш, халаалт	194,972,800.00	292,076,435.16
2104	Хангамж, бараа материалын зардал	4,744,585.00	6,949,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,025,500.00	6,949,500.00
2105	Нормативт зардал	141,067,250.00	179,262,100.00
210502	Хоол, хүнс	140,726,250.00	179,262,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,660,800.00	3,871,500.00
210604	Урсгал засвар	1,660,800.00	3,871,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,666,700.00	1,811,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,666,700.00	1,811,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,467,768.49	115,717,839.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,201,270.00	38,987,833.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,515,579.98	9,363,549.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,750,918.51	67,366,456.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>67,890,351.78</u>	<u>102,679,847.45</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>67,890,351.78</u>	<u>102,679,847.45</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	2,032,438,384.51	3,734,595,867.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	2,032,438,384.51	3,734,595,867.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	102,679,847.45	102,679,847.45
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	2,135,118,231.96	3,837,275,714.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,546,507,500.00	2,004,240,186.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,546,507,500.00	2,004,240,186.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,546,507,500.00	2,004,240,186.53
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,177,000.00	308,626,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,287,330,500.00	1,695,613,886.53
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,546,284,507.00	1,890,314,952.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,546,284,507.00	1,890,314,952.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,507,368,400.00	1,836,600,352.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	947,835,200.00	1,160,016,144.74
210101	Үндсэн цалин	717,818,810.35	754,966,507.52
210102	Нэмэгдэл	210,304,088.70	356,174,818.89
210104	Урамшуулал	19,712,300.95	48,874,818.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,536,500.00	155,724,407.92
210201	Тэтгэврийн даатгал	80,501,300.00	104,728,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,388,100.00	12,320,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,670,700.00	9,951,957.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,886,500.00	4,081,350.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,089,900.00	24,641,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,234,300.00	301,489,541.00

210301	Гэрэл, цахилгаан	11,381,500.00	10,180,541.00
210302	Түлш, халаалт	194,972,800.00	291,309,000.00
2105	Нормативт зардал	145,783,700.00	129,878,300.00
210502	Хоол, хүнс	144,583,700.00	129,878,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,660,800.00	7,136,759.00
210604	Урсгал засвар	1,660,800.00	7,136,759.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,692,200.00	6,770,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,692,200.00	6,770,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,625,700.00	75,584,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,087,400.00	63,976,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,538,300.00	11,608,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,916,107.00	53,714,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,916,107.00	53,714,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,658,700.00	53,714,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	222,993.00	113,925,233.87
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	222,993.00	113,925,233.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		480,400.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	480,400.00	110,837,633.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1997326100.00	1891517952.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1997326100.00	1891517952.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1943778000.00	1837803352.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1255381300.00	1160016144.74
210101	Үндсэн цалин	873529900.00	754966507.52
210102	Нэмэгдэл	332890300.00	356174818.89
210104	Урамшуулал	48961100.00	48874818.33
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156922700.00	155724407.92
210201	Тэтгэврийн даатгал	106707400.00	104728600.00

210202	Тэтгэмжийн даатгал	12553800.00	12320900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10043100.00	9951957.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2510800.00	4081350.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25107600.00	24641600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	301403000.00	301403000.00
210301	Гэрэл, цахилгаан	10091000.00	10091000.00
210302	Түлш, халаалт	291312000.00	291312000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	138,813,500.00	131,078,300.00
210502	Хоол, хүнс	138,813,500.00	129,878,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,226,300.00	7,226,300.00
210604	Урсгал засвар	7,226,300.00	7,226,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,738,900.00	6,770,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,738,900.00	6,770,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,292,300.00	75,584,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,684,000.00	63,976,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,608,300.00	11,608,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,548,100.00	53,714,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,548,100.00	53,714,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,548,100.00	53,714,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,997,324,100.00	2,004,240,186.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,997,324,100.00	2,004,240,186.53
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,688,697,800.00	1,695,613,886.53
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	308,626,300.00	308,626,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		480,400.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		110,837,633.87
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70.00	70.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
620004	Гэрээт ажилтан	10.00	10.00

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	70.00	70.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	38.00	38.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	21.00
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 135,614.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 25,720.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Аудитаар 25,720.0 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Цалингийн сан тооцооллоор ХАОАТ -т илүү шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг авлага бүртгээгүй.
- Худалдан авсан бараа материалыг орлогод аваагүй,
- Бусдад авах бараа материалын авлагыг бүртгээгүй

Эдгээр алдааг залруулснаар санхүүгийн байдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайланд өөрчлөлт орж, үр дүнд нөлөөлсөн.

Залруулагдаагүй нийт 109,894.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 109,894.2 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 2,118.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт, 107,776.2 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1.Төлбөрийн акт

- Тайлан балансын бараа материалын дансанд бүртгэлтэй 2,118.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй 153 ширхэг 5 см банз бодитоор оршин байхгүй зөрчил дутагдал илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.4.- д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ” гэсэнтэй нийцэхгүй байгаад төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 8,626.1 мянган төгрөгийн хүнсний ногоо, мах, сүү зэрэг түргэн муудах хүнсний материалын эхний үлдэгдлийг зарлагадаагүй байгаа нь бараа материалын өртгийн бүртгэлийг зөрчсөн, 28,814.1 мянган төгрөгийн хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй, 708 ширхэг 6,200.0 сая төгрөгийн наран цэцгийн тос худалдан авч, өдөрт 3 ширхэг наран цэцгийн тос зарцуулж байгаа нь материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байгаа зэрэг зөрчил дутагдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бодогч нар хариуцна", Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.22-д "Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагадах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийх, бараа материалын өртгийн бүртгэлийг үнэн зөв илэрхийлэх. Зарцуулалтад бүртгэл тавих хяналтыг сайжруулах.

3.2.2. Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүйтэй холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд 97,825.2 мянган төгрөгийн үнийн дүнтэй 7.4 тонн махыг зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг 29,600.0 мянган төгрөгөөр бууруулсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчил дутагдал илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйл Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, 45.3 -д "энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Хуулийн хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулах, өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллаж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн ажиллах.

3.2.3. Үндсэн хөрөнгийн бүтгэлтэй холбоотой

Илрүүлэлт.

Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн 42 нэр төрлийн 32,846.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Шийдвэрлэлт: Дээрх хөрөнгийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан данс бүртгэлд тусгаж, зөвлөмжийн биелэлтийг албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлэх.

3.2.4. Зардлын данстай холбоотой асуудлаар

Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зардалд 1,690.0 мянган төгрөгийг зарцуулсан гүйцэтгэлийг үр дүнгийн тайлан байхгүй, анхан баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн байгаа нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын гүйцэтгэлд хяналт хийж, анхан шатны баримтыг бүрдүүлэн авч санхүүгийн тайланд хавсаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Ховд сумын сургууль	Цалингийн сан тооцооллоор ХАОАТ -т илүү шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг авлага бүртгээгүй	1	6,420.0	1	6,420.0			1	6,420.0				
	Худалдан авсан бараа материалыг орлогод аваагүй,	1	18,000.0	1	18,000.0			1	18,000.0				
	Бусдад авах бараа материалын авлагыг бүртгээгүй	1	1,300	1	1,300			1	1,300.0				
Нийт		3	25,720.0	3	25,720.0			3	25,720.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хя		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
	Тайлан балансын бараа материалын дансанд бүртгэлтэй 2,118.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй 153 ширхэг 5 см банз бодитоор оршин байхгүй	1	2,118.0	1	2,118.0							
Ховд сумын сургууль	Тайлант онд 8,626.1 мянган төгрөгийн хүнсний ногоо, мах, сүү зэрэг түргэн муудах хүнсний материалын эхний үлдэгдлийг зарлагадаагүй байгаа нь бараа материалын өртгийн бүртгэлийг зөрчсөн, 28,814.1 мянган төгрөгийн хүнсний бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй, 708 ширхэг 6,200.0 сая төгрөгийн наран цэцгийн тос худалдан авч, өдөрт 3 ширхэг наран цэцгийн тос зарцуулж байгаа нь материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байгаа зэрэг зөрчил дутагдал	1	43,640.2					1	43,640.2			

Ховд сумын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Тайлант онд 97,825.2 мянган төгрөгийн үнийн дүнтэй 7.4 тонн махыг зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг 29,600.0 мянган төгрөгөөр бууруулсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй	1	29,600.0					1	29,600.0		
	Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зардалд 1,690.0 мянган төгрөгийг зарцуулсан гүйцэтгэлийг үр дүнгийн тайлан байхгүй, анхан баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн байгаа	1	1,690.0					1	1,690.0		
	Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн 42 нэр төрлийн 32,846.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй	1	32,846.0					1	32,846.0		
Нийт		5	109,894.2	1	2,118.0			4	107,776.2		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								

Ховд сумын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР